



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 23

№ 01/58 АУА-2018/37/СТА-ТЦ 3

Мандалговь хот

Г Зөрчил арилгуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ. Аудит хийх явцад “Ард телевиз” буюу хувийн байгууллагыг Засаг даргын Тамгын газрын байрны 21.4 м² талбай бүхий өрөөнд үнэ төлбөргүй байрлуулан үйл ажиллагаа явуулж, телевизийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр ашиглуулсан, 1,284,000,000/ нэг сая хоёр наян дөрвөн мянга/ төгрөгийн орлого төвлөрүүлэх боломж алдсан зөрчил илэртээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2.1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах/, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 54 тоот тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 1.6 /Түрээслүүлэгч нь нэг зориулалттай, нэгдмэл байдалтай ашиглагдах цогцолбор орон нутгийн өмчийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөдлөх эд хөрөнгийг түрээслэхдээ Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлийг авч, түрээсийн гэрээг Орон нутгийн өмчийн газрын даргаар батлуулан/ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зхицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.1 /Төрийн байгууллагын байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно/ дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ажлаа аудитор, ажлаа шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зорчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.2-т /Омч хөрөнгийг зохих шийдвэргүйгээр бусдад зүй бусаар ашиглуулсан, зах зээлийн үнэж олоор үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Орон нутгийн хөрөнгийг хяналтгүй ашиглуулж байгаа зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох журмыг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Эрдэнэсүрэн, нягтлан бодогч Д.Нандинцэцэг нарт хариуцуулав.

ӨГСӨН¹ :
АУДИТОР *Тамгын* Б.ГАНТУЯА



АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨРИНӨӨРСӨН:
ДАРГА *Ц.Эрдэнэсүрэн* Ц.ЭРДЭНЭСҮРЭН
НЯГТЛАН БОДОГЧ *Д.Нандинцэцэг* Д.НАНДИНЦЭЦЭГ



¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ./